

ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2020 оны 03-р сарын 30

№ ХЭХ-20/1

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр, 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №ТК-20/1 тоот тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.
2. Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Т. Баярмаа/ -д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



/П.ОЧИРХУЯГ/

ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2020 оны 03-р сарын 30

№ ХЭХ-20/2

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох тухай

Глобал лайф технологи ХК-ийн Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.2, 77.4, 2020 оны 3 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ТК-20/1 тоот шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй улируулан сонгож батлуулсугай.

Ноён П.Очирхуяг (хараат гишүүн)

Хатагтай Ц. Оюунтуяа (хараат гишүүн)

Ноён Б. Отгонбаатар (хараат гишүүн)

Ноён Yeh Montgomer (хараат гишүүн)

Хатагтай Lin Yu Fei (хараат гишүүн)

Ноён He Shanjun (хараат гишүүн)

Ноён Tsai Chin-kun (хараат бус гишүүн)

Ноён Ku Cheng-Chuan (хараат бус гишүүн)

Ноён Shih Pei Chih (хараат бус гишүүн)

2. Компанийн дүрмийн 7.40-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг 3 жилээр тогтоож батлуулсугай.

3. Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Т. Баярмаа/ -д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



/П.ОЧИРХУЯГ/

ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2020 оны 03-р сарын 30

№ ХЭХ-20/3

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай

“Глобал лайф технологи” ХК-ийн 2020 оны 3 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тоологын комиссын ТК-20/1 тоот тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Т. Баярмаа/ -д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



/П.ОЧИРХУЯГ/